



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/488

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.10 дахь заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Боловсролын салбарын мэдээллийн систем ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, зохицуулах журам”-ыг нэгдүгээр, мэдээллийн системийн бичиг баримтын бүрдлийг хоёрдугаар, мэдээлэл солилцох мэдээллийн системд тавих ерөнхий шаардлагыг гуравдугаар, мэдээллийн системийн нэвтрэх эрхийн зохицуулалтыг дөрөвдүгээр, мэдээлэл солилцооны сервис үйлчилгээний мэдээллийн жагсаалтыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмыг яам, агентлаг, салбарын байгууллагад танилцуулж, хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар /П.Оюунаа/, Цахим бодлого, статистикийн хэлтэс /Г.Бат-Эрдэнэ/ нарт тус тус даалгасугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг хагас, бүтэн жилээр танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ч.Энх-Амгалан/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны “Журам, загвар батлах тухай” А/286 дугаар, 2020 оны “Журам батлах тухай” А/265 дугаар, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Журам, загвар батлах тухай” А/09, “Мэдээлэл солилцох арга хэмжээний тухай” А/403 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142211953

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/488 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ АШИГЛАХ, МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ, ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.10 дахь заалтыг үндэслэн Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага /цаашид “ям” гэх/-ын хариуцсан боловсролын салбарын мэдээллийн систем /цаашид “мэдээллийн систем” гэх/-ийг хөгжүүлэх, нэвтрүүлэх, ашиглах, мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаажуулах, баяжуулах, хадгалах, хамгаалах, мэдээлэл солилцохтой холбогдон гарах харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Мэдээллийн систем болон мэдээллийн санг ашигладаг, мэдээлэл солилцох эрх бүхий хүн, хуулийн этгээд нь энэхүү журмыг мөрдөнө.
- 1.3. Мэдээллийн эзэн нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасан үүргийг хүлээнэ.
- 1.4. Хүн, хуулийн этгээд нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээнэ.

ХОЁР. МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ

- 2.1. “Боловсролын салбарын мэдээллийн систем” гэж Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасныг ойлгоно.
- 2.2. Мэдээллийн систем нь боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, зөвшөөрөл, магадлан итгэмжлэл, хүний нөөц, үндсэн хөрөнгө, төсөв, санхүү, шагнал урамшуулал, сурах бичиг болон суралцахуйн удирдлага, боловсролын үнэлгээ, сургалтын зээл, тэтгэлгийн үйл ажиллагаа, тайлагналтыг салбарын хэмжээнд нэгдсэн мэдээллийн урсгалаар хангах бөгөөд боловсролын түвшин бүрээр мэдээлэл солилцох боломжтой байна.
- 2.3. Энэхүү журмын 2.2-т заасан дэд системүүд нь дараах чиглэлтэй байна. Үүнд:
 - 2.3.1. Байгууллагын удирдлагын систем
 - 2.3.2. Зөвшөөрөл болон магадлан итгэмжлэлийн систем
 - 2.3.3. Санхүү, хөрөнгө оруулалтын систем
 - 2.3.4. Суралцахуйн удирдлагын систем /Элсэлт, анги, бүлэг, ирц, үнэлгээ, шилжилт хөдөлгөөн, хоол тэжээл, төгсөлт, шалгалт, боловсролын баримт бичиг, хувийн хэрэг, хөтөлбөр, төлөвлөгөө, даалгаврын сан, асуулгын систем гэх мэт/
 - 2.3.5. Багшийн мэдээллийн систем
 - 2.3.6. Эцэг, эх, асран хамгаалагчийн мэдээллийн систем
 - 2.3.7. Судлагдахуун, хичээлийн сан (контент)-ийн платформ
 - 2.3.8. Цахим номын сангийн удирдлагын систем
 - 2.3.9. Төлбөр тооцооны удирдлагын систем
 - 2.3.10. Боловсролын үнэлгээний систем

2.3.11. Боловсролын зээл, тэтгэлгийн удирдлагын систем

2.3.12. Боловсролын төрийн үйлчилгээний систем

2.3.13. Хуульд заасан бусад

2.4. Мэдээллийн системийн хөгжүүлэлтийн бодлогын даалгаврыг боловсруулахдаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн дагуу цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулах ба өгөгдөл болон маягт хоорондын логик уялдаа холбоог хангах, яамны тухайн салбар нэгжээс саналыг авч, тусгана.

2.5. Яам нь мэдээллийн системийн бүтэц, бодлогын даалгаврыг баталж, Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ-т хүргүүлнэ.

2.6. Яам нь боловсролын сургалтын байгууллагын болон суралцахуйн удирдлагын системд тавих шаардлага (тухайлсан)-ыг батална.

2.7. Багшийн цахим журнал, анги удирдсан багшийн цахим дэвтэр, сурагчийн бүртгэл мэдээлэл (хувийн хэрэг)-ийг хөтлөх, сургалтын баримт бичиг олгох үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

2.8. Мэдээллийн систем нь боловсролын салбарын статистик, мэдээ, мэдээллийг бодит цаг хугацаанд нэгтгэн боловсруулах, график хэлбэрээр дүрслэн үзүүлэх ухаалаг тайлангийн системтэй байна.

2.9. Дараах байгууллагууд мэдээлэл хариуцагч байна. Үүнд:

2.9.1. Яам

2.9.2. Мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, баталгаажуулах, нэвтрүүлэх чиг үүргийн хүрээнд: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Боловсролын ерөнхий газар” гэх), боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага болон бүх түвшний боловсролын сургалтын байгууллага

2.9.3. Мэдээллийн систем болон мэдээллийн санг хөгжүүлэх, хадгалах, хамгаалах чиг үүргийн хүрээнд: Боловсролын мэдээллийн технологийн төв УТҮГ (цаашид “Төв” гэх)

2.9.4. Мэдээллийн систем болон мэдээллийн санг ашиглах, нэвтрүүлэх чиг үүргийн хүрээнд: Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, Боловсролын үнэлгээний байгууллага, Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага болон Боловсролын зээлийн сан

ГУРАВ. МЭДЭЭЛЛИЙН САН

3.1. Боловсролын салбар нь мэдээллийн нэгдсэн сантай байх бөгөөд уг сан нь төрийн өмч байна.

3.2. “Мэдээллийн сан” гэж боловсролын салбарын хүний нөөц, суралцагч ба түүний мэдээлэл, боловсролын сургалтын үйл ажиллагаа, үйл явц, үр дүн, баримт бичиг, тайлан, мэдээ, үзүүлэлт болон салбарын бусад мэдээллийг агуулсан төрөлжсөн болон байгууллагын мэдээллийн санг ойлгоно.

3.3. Мэдээлэл хариуцагч гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгоно.

3.4. Мэдээлэл хариуцагч нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 27.10-т заасан нэгдсэн ангилал, код, тайлбарыг мөрдөнө. Мэдээллийн сангийн ангилал, код, тайлбарыг давхардуулахгүй.

3.5. Мэдээллийн санд мэдээлэл оруулах, өөрчлөх, боловсруулах, баталгаажуулах ажлыг хариуцсан чиг үүрэг бүхий ажилтан, алтан тушаалтан гүйцэтгэх ба үнэн бодит байдлыг хангаж, системд нэвтрэх эрх, нууц үгийг ажилтан өөрөө хариуцна.

3.6. Мэдээллийн сан, түүний боловсруулалтын үр дүн, холбогдох тайлан нь мэдээлэл хариуцагчийн албан ёсны мэдээ, мэдээлэл, баримт бичиг байх бөгөөд улсын хэмжээнд үйлчилнэ.

3.7. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн санг бүрдүүлж, баяжуулахдаа Статистикийн тухай хуулийн хүрээнд батлагдсан үзүүлэлт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд шинэчлэн бүртгэж, мэдээллийн бүрэн гүйцэд, үнэн зөв, бодит байдлыг хангана.

3.8. Мэдээллийн санд боловсролын баримт бичиг (үнэмлэх, гэрчилгээ, диплом)-ийн мэдээллийг төвлөрүүлэн байршуулах бөгөөд блокчэйн технологи ашиглан баталгаажуулна.

3.9. Мэдээллийн санд агуулагдаж буй салбарын нээлттэй мэдээллийг холбогдох хууль, журамд заасны дагуу нээлттэй өгөгдөл болгон ашиглаж болно.

3.10. Мэдээллийн санд бүрэн бус, алдаатай мэдээлэл илэрсэн нь нотлох баримтаар батлагдсан бол залруулга, засварыг хийхдээ дараах дарааллыг баримтална. Үүнд

3.10.1. Мэдээлэл хариуцагч, түүний ажилтан, албан хаагч нь зөвхөн өөрийн бүртгэсэн, бүрдүүлэлт, баяжуулалт хийсэн мэдээлэлд залруулга, засвар хийх зарчмыг баримтлах бөгөөд дээд шатны системд хандах эрхтэй албан тушаалтан нь бусдын өмнөөс засвар өөрчлөлт хийхгүй байх

3.10.2. Боловсролын ерөнхий газар, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь залруулга, засвар хийх тухай мэдэгдлийг нотлох баримтын хамт мэдээлэл хариуцагчид хүргүүлэх

3.10.3. Мэдэгдэл хүлээн авсан мэдээлэл хариуцагч нь ажлын 2 хоногт багтаж залруулга, засварыг хийж, эргэн мэдээлэх

3.10.4. Хэрэв мэдээлэл хариуцагч нь татан буугдсан бол Боловсролын ерөнхий газар, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын чиг үүрэг бүхий албан тушаалтан нь залруулга, засварыг хийх

3.10.5. Залруулга, засвар хийсэн түүх, нотлох баримтыг архивлан хадгалах

3.10.6. Боловсролын ерөнхий газар нь залруулга, засвартай холбоотой салбарын нэгдсэн тайланг жил бүр гаргаж, яаманд хүргүүлэх

3.11. Мэдээлэл хариуцагчид мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээлэлд иргэн, хуулийн этгээдээс гомдол санал ирүүлсэн тохиолдолд үнэн бодит эсэхийг магадлан шалгаж хариу мэдэгдэнэ.

3.12. Мэдээллийн санг Архивын тухай хууль болон бусад хууль, журамд заасан хугацаанд хадгална.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОО

4.1. “Боловсролын салбарын мэдээлэл солилцооны систем” /цаашид “мэдээлэл солилцооны систем”/ гэж боловсролын салбарт ашиглагдаж буй мэдээллийн систем, программ хангамж, тэдгээрийн мэдээллийн сан хооронд харилцан мэдээлэл солилцох зориулалттай систем бөгөөд тархмал бүтэц бүхий төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем (үндсэн систем)-ийн нэг хэсэг байна.

4.2. Яам нь мэдээлэл солилцооны системийн сервис үйлчилгээ, түүний мэдээллийн жагсаалтыг батална.

4.3. Яам нь мэдээлэл солилцооны системтэй байна.

4.4. Мэдээлэл солилцооны систем нь энэхүү журмын хоёрдугаар хавсралт дахь мэдээллийн системийн бичиг баримтыг бүрдүүлсэн, гуравдугаар хавсралт дахь мэдээлэл солилцох мэдээллийн системд тавих ерөнхий шаардлагыг хангасан системтэй тавдугаар хавсралт дахь мэдээлэл солилцооны сервис үйлчилгээний мэдээллийн жагсаалтад багтсан мэдээллийг харилцан солилцоно.

4.5. Мэдээлэл солилцооны системийг боловсролын салбарын хэмжээнд ашиглах бөгөөд бусад салбар хооронд мэдээлэл солилцохдоо үндсэн системтэй холбогдож ажиллана.

- 4.6. Яам нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 196 дугаар тогтоолын дагуу боловсролын салбарын хэмжээнд үндсэн болон дэмжих системийг ашиглан үйлчилгээ авах гэрээг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай байгуулж, хуулбарыг төвд хүргүүлнэ.
- 4.7. Төв нь мэдээлэл солилцооны системийн сервис үйлчилгээний гарын авлагыг боловсруулж, нэгдсэн хэлбэрээр цахим хуудсанд байршуулна.
- 4.8. Яам нь мэдээлэл солилцох тухай хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх, гэрээ байгуулах болон сервисийн хөгжүүлэлт, холболт, туршилт, түүний хандалтыг бодит цаг хугацаанд хянах бүртгэлийн системтэй байх ба тус бүртгэлийн системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг төв хариуцна.
- 4.9. Систем хөгжүүлэгч (боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглах байгууллагын болон суралцахуйн удирдлагын систем хөгжүүлэгч хуулийн этгээд) нь системийн үйлчилгээ үзүүлж буй боловсролын сургалтын байгууллагатай холбогдох хууль, журмын дагуу гэрээ байгуулсан байна.
- 4.10. Энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасан мэдээлэл солилцох мэдээллийн системд тавих ерөнхий шаардлагыг хангасан систем хөгжүүлэгч нь мэдээлэл солилцох тухай албан хүсэлт, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1.9, 4.1.10 дахь заалтын дагуу холбогдох дүгнэлтүүд, сервис үйлчилгээний нэр, зориулалт, холбоо барих мэдээллийг яаманд хүргүүлнэ.
- 4.11. Яам нь энэ журмын 4.10-д заасан албан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.
- 4.12. Яам нь энэхүү журмын гуравдугаар хавсралтад заагдсан мэдээлэл солилцох мэдээллийн системд тавих ерөнхий шаардлагыг хангасан систем хөгжүүлэгчтэй мэдээлэл солилцох гэрээ байгуулж, Төв, Боловсролын ерөнхий газар болон тухайн боловсролын сургалтын байгууллагад хуулбарыг хүргүүлнэ.
- 4.13. Мэдээлэл солилцох гэрээний хугацаа нь энэхүү журмын 4.9-д заасан гэрээний хугацаатай ижил байна.
- 4.14. Төв нь мэдээлэл солилцох гэрээг хүлээн авснаас хойш хөгжүүлэлтийг ажлын 15 хоногт багтаан хийж, ашиглалтад оруулна.
- 4.15. Яам нь гэрээний бүртгэлийн санг хөтөлж, хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

ТАВ. БОЛОВСРОЛЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМААР ҮЗҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТ

5.1. Боловсролын доор дурдсан үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлнэ. Үүнд:

- 5.1.1. Зөвшөөрлийн үйлчилгээ
- 5.1.2. Магадлан итгэмжлэлийн үйлчилгээ
- 5.1.3. Боловсролын баримт бичиг, бусад лавлагаа, тодорхойлолт олгох үйлчилгээ
- 5.1.4. Суралцагчийн суралцахуйд чиглэсэн бүртгэл, мэдээллийн үйлчилгээ
- 5.1.5. Сургалтын төлбөрийн зээл, тэтгэлгийн үйлчилгээ
- 5.1.6. Суралцагчийн эцэг, эх, асран хамгаалагчид чиглэсэн үйлчилгээ
- 5.1.7. Бүх нийтийг салбарын нээлттэй мэдээллээр хангах үйлчилгээ
- 5.1.8. Бусад

5.2. Энэ журмын 5.1-д заасан үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхдээ мэдээллийн санд түшиглэх ба мэдээллийн систем, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (И-Монголиа), төрийн үйлчилгээний цахим машин (ТҮЦ), болон тэдгээртэй холбогдон ажиллах гар утасны аппликэйшн, бусад автомат машин, киоск, ухаалаг дэлгэц, тоног төхөөрөмжийг ашиглана.

5.3. Боловсролын төрийн үйлчилгээний цахим хэлбэртэй мэдээлэл нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчин төгөлдөр байна.

5.4. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (И-Монголиа)-ээр дамжуулан олгохоос бусад лавлагаа, тодорхойлолтын загварыг яам батална.

5.5. Боловсролын бүх төрлийн лавлагаа, тодорхойлолт дугаарын давхардалгүй, монгол, англи хэлний сонголттой байх ба олгосон өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

5.6. Боловсролын баримт бичиг, лавлагаа тодорхойлолт олгох болон бусад хязгаарлалттай мэдээлэлд хандах, дамжуулах тохиолдолд мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах ба Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 211 дүгээр тогтоолд заасны дагуу бүртгэн, мэдэгдэл хүргэнэ.

5.7. Цаасан хэлбэрээр мэдээлэл, лавлагаа, тодорхойлолт өгөхтэй холбогдох зардлыг Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 206 дугаар тогтоолоор, Засгийн газраас баталсан нээлттэй өгөгдлийн жагсаалтад ороогүй, эсхүл нээлттэй өгөгдлийг нийтлэхээс өмнө хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр нээлттэй өгөгдөл боловсруулж өгөх төлбөрийг Засгийн газрын 2022 оны “Аргачлал батлах тухай” 202 дугаар тогтоолоор баталсан аргачлалаар тус тус тооцно.

5.8. Цахим хэлбэрээр үйлчилгээ авахдаа гуравдагч этгээдээр дамжуулан хүсэлт ирүүлсэн бол тухайн хүн, хуулийн этгээдийг хууль, журмын дагуу таньж баталгаажуулна.

5.9. Зөвшөөрлийн болон магадлан итгэмжлэлийн үйлчилгээг цахимаар үзүүлэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохицуулна.

5.10. Бүх нийтийг салбарын нээлттэй мэдээллээр хангах, мэдээллийн сан дахь нээлттэй мэдээллийг нийтлэх, шинэчлэх, хяналт тавих болон нээлттэй өгөгдөл болгож ашиглах үйл ажиллагаанд Засгийн газрын 2022 оны 200, 201, 206 дугаар тус тус тогтоолыг мөрдөнө.

5.11. Боловсролын ерөнхий газар нь мэдээллийн санд нөхөн бүрдүүлэлт, иргэнд үзүүлэх үйлчилгээг хийхтэй холбогдох асуудлыг Архивын ерөнхий хууль, бусад хуульд үндэслэн, шийдвэрлэж, тухай бүрд яаманд тайлагнана. Үүнд:

5.11.1. 2018 оноос өмнө олгогдсон боловсролын баримт бичгийг Архивын ерөнхий газар болон боловсролын сургалтын байгууллагын архивын мэдээлэл, статистикийн мэдээлэлд тус тус үндэслэн мэдээллийн системд оруулна. Хэрэв өмнөх онуудад олгогдсон боловсролын баримт бичгийн дугаар давхардсан тохиолдолд аль нэг байгууллагын мэдээллийн ард “ * ” тэмдэглэл хийж оруулна.

5.11.2. Боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх/-ийг иргэнд дахин олгосон тохиолдолд шинээр олгосон баримт бичгийн дугаарыг боловсролын сургалтын байгууллага тухай бүр мэдээллийн системд бүртгэж, дахин олгосон шалтгааныг бичнэ.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

6.1. Мэдээллийн санг “Боловсролын дата төв” болон “Үндэсний дата төв”-д газар зүйн өөр байршилд байршуулах ба нөөц (backup) болон толин сервер (mirror)-ийн дэд бүтэцтэй байна.

6.2. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн систем болон мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авна. Үүнд:

- 6.2.1. Болзошгүй аюул болон эмзэг байдал, эрсдэлийг тодорхойлж, түүний магадлалыг тооцоолох
- 6.2.2. Аюулгүй байдлыг хангах ажиглалтыг тасралтгүй хийж, будилааны бүртгэлийг хөтөлж, нэгтгэх
- 6.2.3. Нууцлал, аюулгүй байдал алдагдсан гэж үзвэл шуурхай хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх
- 6.2.4. Нууц үгийн нууцлал, аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлэх
- 6.2.5. Нууцлал, аюулгүй байдлын чиглэлээр холбогдох сургалтыг зохион байгуулж, шаардлага тавих

- 6.3. Мэдээллийн систем болон мэдээллийн санг ашиглаж буй ажилтан нь “Нууцын баталгаа”-г гаргана.
- 6.4. Мэдээлэл хариуцагч нь салбарын мэдээллийн аюулгүй байдлын журам, холбогдох стандартыг чанд мөрдөж, төвийн зөвлөмж, шаардлагыг биелүүлнэ.
- 6.5. Мэдээллийн системийн хөгжүүлэлтийг зориулалтын орчинд хийх ба туршилтад ашиглах бодит бус мэдээллийн сантай байна.
- 6.6. Мэдээллийн систем, түүний сервер, сүлжээнд мөрдөгдөж буй дүрэм, журам, зааврыг виртуал серверүүд дээр нэгэн адил мөрдөнө.
- 6.7. Мэдээллийн систем нь түгшүүр болон анхааруулгатай байна.
- 6.8. SSL шифрлэлт болон ашиглагдаж буй программ хангамжуудыг албан ёсны лицензтэй хэрэглэнэ.
- 6.9. Нэвтрэх эрх хаагдсан, түдгэлзүүлсэн хэрэглэгчийн систем ашиглаж байсан үеийн түүхийг устгахгүй, хууль журамд заасан хугацаагаар хадгална.
- 6.10. Мэдээллийн системийн хэрэглэгч, түүний үйлдэл тус бүрд аудит “Лог”-ийг бүртгэж, хялбар хянана.
- 6.11. Мэдээллийн систем болон мэдээллийн санд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл үүссэн, сэжигтэй хандалт илэрсэн, гэрээнд зааснаас өөр зорилгоор мэдээллийг ашигласан зэрэг болон эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд тухайн системийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зогсооно.
- 6.12. Яам нь мэдээллийн систем болон мэдээллийн сангийн үйл ажиллагаа, чанарт төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийх, жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж шаардлагатай арга хэмжээг авах ба кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэнэ.

ДОЛОО. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 7.1. Мэдээлэл хариуцагч байгууллагын нийтлэг үйл ажиллагаа
 - 7.1.1. Мэдээллийн “Системийн администратор” (системд хэрэглэгчийн эрх, байгууллагын үйл ажиллагааны тохиргоо, түүний өөрчлөлтийг хариуцах эрх бүхий ажилтныг)-ыг томилох, сургах
 - 7.1.2. Мэдээллийн сангийн мэдээллийг бодит цаг хугацаанд, үнэн зөв бүрдүүлэх, баяжуулах, хяналт тавьж ажиллах
 - 7.1.3. Нийт багш, ажилтан, суралцагч, тэдгээрийн эцэг, эх, асран хамгаалагч нарт мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулах
 - 7.1.4. Мэдээллийн систем ашиглах техник хангамж, сүлжээний бэлэн байдал, тасралтгүй найдвартай ажиллагааг хангах
- 7.2. Мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, баталгаажуулах, нэвтрүүлэх байгууллагын үйл ажиллагаа
 - 7.2.1. Мэдээллийн системийг ашиглах, мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр төрөл бүрийн чадавх бэхжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах, үр дүнг хянах

7.2.2. Мэдээллийн санд боловсролын баримт бичгийн бүрдүүлэлт, баяжуулалт хийх үйл ажиллагааг зохион байгуулж, тухай бүрд баталгаажуулах

7.2.3. Гадаадаас шилжиж ирж буй суралцагчийн дүйцүүлэх тодорхойлолт болон суурь бүрэн дунд боловсролоо дүйцүүлүүлэх тухай иргэний хүсэлт, холбогдох материалыг хүлээж авснаас хойш ажлын 3 хоногт багтаж шийдвэрлэх, бүртгэх, баталгаажуулах, эргэн мэдээлэх

7.2.4. Мэдээллийн санд статистик мэдээ, тайлан, бусад судалгаа, мэдээллийг батлагдсан буюу зөвшөөрөгдсөн үзүүлэлт, аргачлалын дагуу тогтоосон хугацаанд бүрдүүлж, баяжуулах, үнэн зөв, бодит, чанартай байдлыг хангаж, өдөр тутмын урсгалыг хянах

7.2.5. Мэдээллийн сан дахь мэдээллийн хамралтад хяналт тавьж, тайланг хянаж баталгаажуулах

7.3. Мэдээллийн систем болон мэдээллийн санг хөгжүүлэх, хадгалах, хамгаалах байгууллагын үйл ажиллагаа

7.3.1. Мэдээллийн систем, мэдээллийн сан, мэдээлэл солилцооны системийн хөгжүүлэлт, тогтвортой ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хариуцах

7.3.2. Энэхүү журмын нэгдүгээр хавсралт дахь мэдээллийн системийн бичиг баримтыг бүрдүүлэх, тухай бүрд шинэчлэх, яаманд хүргүүлэх

7.3.3. Мэдээллийн системийн болон сервис үйлчилгээний гарын авлагыг боловсруулах, тогтмол шинэчлэх

7.3.4. Мэдээлэл солилцох гэрээ хийсэн хуулийн этгээд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, техникийн нөхцөл шаардлагыг зөрчсөн, холбогдсон сүлжээгээр дамжуулан зориулалтын бус үйлдэл хийсэн бол тухайн байгууллагад мэдэгдэх

7.3.5. Салбарын статистик мэдээллийн анхан шатны, бүртгэлийн, захиргааны болон албан ёсны маягт шинэчлэгдэх бүрд мэдээллийн системийн хөгжүүлэлтийн ажлыг тухай бүрд хийх

7.3.6. Мэдээллийн санд өгөгдөл, мэдээллийг давхцалгүй, чанартай бүрдүүлэх, нэг эх үүсвэртэй байлгахад технологийн бодлогыг хэрэгжүүлэх замаар мэдээлэл хариуцагч нарт дэмжлэг үзүүлэх

7.3.7. Төрийн байгууллаас хүргүүлж буй нөхцөл, шаардлагыг биелүүлж ажиллах

7.3.8. Нууцын баталгаа гаргах

7.4. Мэдээллийн систем болон мэдээллийн санг ашиглах, нэвтрүүлэх байгууллагын үйл ажиллагаа

7.4.1. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллагуудын хэмжээнд мэдээллийн систем ашиглалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, түүний үнэн бодит байдалд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх

7.4.2. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь мэдээллийн системийн сургалт, эрдэм шинжилгээ, хөтөлбөр, төлөвлөгөөний хэсэг, түүний мэдээллийн сангийн чанарыг хариуцах

7.4.3. Боловсролын үнэлгээний байгууллага нь мэдээллийн системийн боловсролын үнэлгээний болон шалгалтын систем, нээлтэй даалгаврын сан, түүний мэдээллийн сангийн чанарыг хариуцах

7.4.4. Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь мэдээллийн системийн магадлан итгэмжлэлийн хэсэг, түүний мэдээллийн сангийн чанарыг хариуцах


7.4.5. Боловсролын зээлийн сан нь мэдээллийн системийн сургалтын зээл, тэтгэлгийн хэсэг, түүний мэдээллийн сангийн чанарыг хариуцах

НАЙМ. ХАРИУЦЛАГА

- 8.1. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн сангаас бусад эх үүсвэрээс олж авсан, боловсруулсан аливаа мэдээ, мэдээлэлд хариуцлага хүлээхгүй.
- 8.2. Төв, түүний программистууд нь мэдээллийн санд өөрчлөлт, засвар оруулах, мэдээллийг бусдад дамжуулах, нийтэд мэдээлэхгүй.
- 8.3. Мэдээллийн систем болон мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангаагүйтэй холбогдон гарах аливаа эрсдэлд төв болон систем хөгжүүлэгч байгууллага нь холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хариуцлага хүлээнэ.
- 8.4. Мэдээллийн сан ашиглах чиг үүрэг бүхий ажилтан нь албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглах болон гуравдагч этгээдэд дамжуулахгүй.
- 8.5. Мэдээллийн сангийн зөрүүтэй, алдаатай, хамралт дутуу бүрдүүлэлтээс үүсэх аливаа асуудлыг тухайн бүртгэсэн, нэгтгэсэн, хянасан мэдээлэл хариуцагч байгууллагын буруутай ажилтан, албан тушаалтан хариуцна.
- 8.6. Мэдээллийн сангийн мэдээллийг удаа дараалан хамралт дутуу, чанаргүй бүртгэсэн, нэгтгэсэн, хариуцлагагүй хянасан ажилтан, албан тушаалтанд Төрийн албан тухай хууль, Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу шат дараалсан хариуцлага тооцож, үр дүнг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдээлнэ.
- 8.7. Мэдээллийн сан ашиглах чиг үүрэг бүхий ажилтан нь албан үүргийн дагуу олж авсан мэдээллийг хувийн зорилгоор ашиглах болон гуравдагч этгээдэд дамжуулахыг хатуу хориглоно.
- 8.8. Захиргааны болон албан ёсны статистикийн мэдээ, тайлан, тооллого, судалгаа, бүртгэлийг хамралт дутуу цуглуулсан, алдаатай буруу гаргасан, графикт хугацаанаас хоцроосон, заавал хөтлөгдөх анхан шатны болон нягтлан бодох, статистик бүртгэлийн маягт, аргачлалыг аж ахуйн нэгж, байгууллагад мөрдүүлэх ажлаас зайлсхийсэн, батлагдсан маягтын дагуу нэгтгэгдсэн мэдээллийн үнэн, бодит байдлыг хянаагүй буруутай албан хаагч, эдгээрийг хянаагүй удирдах албан тушаалтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан улсын байцаагчийн акт тогтоож, Төрийн албан тухай хууль, Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу холбогдох шат дараалсан хариуцлагыг хүлээлгэнэ.
- 8.9. Энэхүү журмыг зөрчсөн, бүртгэлийн мэдээллийг хуурамчаар хөтөлсөн, зөвшөөрөлгүй ашигласан этгээдэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 36.1, 36.2-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

--- о О о ---

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022
оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/Ч.88
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН БИЧИГ БАРИМТЫН БҮРДЭЛ

Боловсролын салбарт ашиглагдаж буй мэдээллийн системийн бичиг баримт нь дараах бүрдэлтэй байна. Үүнд:

1. Бодлогын даалгавар, техникийн шаардлага
2. Системийн автомат анхааруулга, мэдэгдлийн нөхцөл, түүний тайлбар
3. Аюулгүй байдлын халдлага, будилаан, хариу арга хэмжээний бүртгэл
4. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитын дүгнэлт, зөвлөмж, хэрэгжилтийн тайлан
5. Тохиргооны гарын авлага (видео, файл)
6. Мэдээлэл солилцооны гарын авлага
7. Ашиглах заавар (видео болон файл)
8. Патентын болон зохиогчийн эрхийн гэрчилгээ
9. Систем администраторын жагсаалт, хандах эрхийн түвшин
10. Мэдээллийн системийн үйл ажиллагаатай холбогдох гэрээ

--- о О о ---

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022
оны 11 дүгээр сарын 23 -ны өдрийн А/488
дугаар тушаалын гуравдугаар хавсралт



МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд ашиглах байгууллагын болон суралцахуйн удирдлагын систем нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Боловсролын салбарын мэдээллийн системийн шаардлагад нийцсэн байх
2. Мэдээлэл солилцооны системтэй холбогдож мэдээлэл солилцох боломжтой байх
3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан тухайлсан шаардлагыг хангасан байх
4. Танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-ээр нэвтэрдэг байх
5. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн байх
6. Системд ашиглагдах үг, хэллэг, нэр томъёо болон өгөгдлийн бүтцийг боловсролын салбарт мөрдөгдөж буй дүрэм, журамтай нийцүүлсэн байх
7. Тайлан боловсруулж, татан авах боломжтой байх
8. Аудит "Лог"-ийн түүхчилсэн бүртгэлийг автоматаар хөтлөгддөг ба хялбар хянах боломжтой байх
9. Систем хөгжүүлэлт, туршилтын зориулалтын орчныг бүрдүүлсэн байх
10. Мэдээллийн системийн бичиг баримтыг бүрдүүлсэн байх (энэхүү журмын хавсралт II)
11. Мэдээллийн системийн нэвтрэх эрхийн зохицуулалт, бусад шаардлагатай тохиргоог хялбар удирдах боломжтой байх
12. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын холбогдох журам, стандарт, шаардлагыг хангасан байх
13. Бусад

--- о О о ---


МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМИЙН НЭВТРЭХ ЭРХИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Боловсролын салбарын мэдээллийн систем нь дараах нэвтрэх эрхийн зохицуулалттай байна. Үүнд:

1. Мэдээллийн систем, дэд системд нэг хэрэглэгч нь нэг бүртгэлээр нэвтрэх ба тус эрх нь бүртгэх, засах, харах, хайх зэрэг үйлдэл тус бүрээр зохицуулагдсан байна.
2. Мэдээллийн систем нь дараах нэвтрэх эрхийн түвшинтэй байна. Үүнд:
 - 2.1. Яам нь улсын болон бусад бүх түвшний мэдээлэлд
 - 2.2. Боловсролын ерөнхий газар, Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага, Боловсролын зээлийн сан нь өөрийн үндсэн чиг үүрэгт хамаарах улсын түвшний мэдээлэлд
 - 2.3. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь тухайн орон нутгийн түвшний мэдээлэлд
 - 2.4. Бүх түвшний боловсролын сургалтын байгууллага нь зөвхөн өөрийн байгууллагын түвшний мэдээлэлд
3. Мэдээллийн систем нь нэвтрэх эрхийн түвшин бүрд тохирсон системийн администраторын /цаашид "админ" гэх / хэсэгтэй байна.
4. Мэдээлэл хариуцагч нь мэдээллийн систем хариуцах админыг тушаалаар томилох ба өөрчлөлт орсон дариу холбогдох байгууллагад мэдээлнэ.
5. Төв нь яам, Боловсролын ерөнхий газар, Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага, Боловсролын зээлийн сангийн админд системийн эрх олгох ба хариуцлагын гэрээг байгуулах, өөрчлөлтийг тухай бүрд хийж, жагсаалтыг яаманд хүргүүлнэ.
6. Боловсролын ерөнхий газар болон боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын админд системийн эрх олгох ба үүрэг хариуцлагын гэрээг байгуулж, өөрчлөлтийг тухай бүрд хийж, жагсаалтыг яаманд хүргүүлнэ.
7. Багш, ажилтан, албан хаагч нь нэвтрэх эрхээ өөрийн байгууллагын админаас авах ба системд агуулагдаж буй цахим бичиг баримт, тайлан мэдээ, мэдээллийн эцсийн байдлаар баталгаажуулахдаа тоон гарын үсэг ашиглана.
8. Насанд хүрээгүй суралцагч нь давхардахгүй, тусгай код бүхий нэвтрэх эрхийг анги хариуцсан багш эсвэл сургалтын менежерээс авах ба холбогдох заавартай бүрэн танилцана.
9. Боловсролын үйлчилгээг цахимаар авах хүн, хуулийн этгээд нь мэдээллийн системд хандахдаа танилт, нэвтрэлтийн систем "ДАН"-ийг ашиглана.
10. Мэдээллийн системийн нэвтрэх эрх олгох, өөрчлөх, түдгэлзүүлэхэд нэгдсэн бүртгэлийг цахимаар хөтөлж, тухай бүрд шуурхай шинэчилнэ.
11. Мэдээллийн системийн эрх олгож буй байгууллага, албан тушаалтан нь хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын 3 хоногийн дотор шийдвэрлэж, эргэн мэдээлнэ.
12. Эрх бүхий албан тушаалтан нь мэдээллийн системд нэвтрэх эрхийг нээх, өөрчлөх, түдгэлзүүлэх тухай шийдвэрийг амаар өгөхийг хориглоно.
13. Нэвтрэх эрх авсан багш, ажилтан, албан тушаалтан нь өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахыг хориглоно.

--- o O o ---

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022
оны 11 дүгээр сарын 23 -ны өдрийн А/488
дугаар тушаалын тавдугаар хавсралт



МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ СЕРВИС ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

1. Байгууллагын бүртгэл, мэдээлэлд чиглэсэн

1. Аймаг нийслэлийн төвөөс алслагдсан байдал
2. Байгуулагдсан огноо
3. Байгууллагын ангилал
4. Байгууллагын нэр
5. Байгууллагын нэр /англи/
6. Байгууллагын нэр /товчилсон/
7. Байгууллагын өмчийн хэлбэр
8. Байгууллагын регистрийн дугаар
9. Байгууллагын төлөв
10. Байгууллагын төлөв өөрчлөгдсөн эсэх
11. Байгууллагын үйлдлийн огноо
12. Байгууллагын үйлдлийн төрөл
13. Байгууллагын үйлдлийн шалтгаан
14. Байгууллагын хэв шинж
15. Вэбсайт
16. Гадаадын сургуулийн салбар эсэх
17. Засгийн газар хоорондын гэрээний дагуу байгуулагдсан ерөнхий боловсролын сургууль эсэх
18. Зөвшөөр олгосон огноо
19. Зөвшөөрлийн дүгнэлт
20. Зөвшөөрлийн дугаар
21. Зөвшөөрлийн дуусах огноо
22. Зөвшөөрлийн тушаал, шийдвэрийн дугаар
23. Зөвшөөрлийн тушаал, шийдвэрийн огноо
24. зөвшөөрөл - сургалтын ажил эрхлэх эсэх
25. Зөвшөөрөл авсан салбар
26. Зөвшөөрөл олгосон байгууллага
27. Зөвшөөрөл олгосон байгууллагын албан тушаалтан
28. Зөвшөөрөл хүчинтэй хугацаа
29. Зөвшөөрөл-төлөв
30. Магадлан итгэмжлэгч
31. Магадлан итгэмжлэлийн төрөл
32. Магадлан итгэмжлэлийн хөтөлбөр
33. Магадлан-Бүртгэлийн дугаар
34. Магадлан-Гэрчилгээний дугаар
35. Магадлан-Итгэмжилсэн огноо
36. Магадлан-Тушаал шийдвэр
37. Магадлан-Тушаал шийдвэрийн дугаар
38. Магадлан-Тушаал, шийдвэр гаргагч
39. Магадлан-Тушаал, шийдвэрийн огноо
40. Магадлан-Хугацаа дуусах огноо
41. Магадлан-Явц
42. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн мэдээлэл
43. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн төлөв
44. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн төрөл
45. Утас
46. Факс
47. Хариуцлагын хэлбэр
48. Харьяа байгууллага байгаа эсэх
49. Харьяалагдах байгууллагын нэр
50. Хаяг: Аймаг/нийслэл
51. Хаяг: Баг/хороо
52. Хаяг: Байшин/байр
53. Хаяг: Гудамж/хороолол
54. Хаяг: Сум/дүүрэг
55. Хуулийн этгээдийн төрөл
56. Хүсэлт гаргасан огноо
57. Хэрэв мэргэжлийн сургалтын байгууллага бол хэв шинж
58. Хэрэгжүүлдэг боловсролын түвшин
59. Цахим шуудан

Байгууллагын бүртгэл мэдээллийн дэлгэрэнгүй үзүүлэлт:

№	Төрөл	Үзүүлэлт	
1.	Байгууллагын ангилал	Ахлах сургууль /1-12, 10-12-р ангитай/	
		Бага сургууль /1-5-р ангитай/	
		Бие даасан	
		Дунд сургууль /1-9, 6-9-р ангитай/	
		дээд сургууль	
		Их сургууль	
		Коллеж	
		Сургуульд түшиглэсэн насан туршийн боловсролын төв	
		Цогцолбор сургууль	
		Коллеж /технологийн/	
2.	Байгууллагын өмчийн хэлбэр	Олон нийтийн	Өмчийн
			Оролцоотой
			Гадаадтай хамтарсан
		Орон нутгийн	Өмчийн
			Өмчийн оролцоотой
			Хамтарсан
			Гадаадтай
		Төрийн	Өмчийн
			Өмчийн оролцоотой
			Хамтарсан
			Гадаадтай
		Хувийн	Монгол улсын
			Гадаадтай хамтарсан
			Гадаад улсын
		Шашны	Өмчийн
			Өмчийн оролцоотой
Өмчийн, гадаадтай хамтарсан			
3.	Байгууллагын төлөв	Ангилал өөрчлөгдөх	
		Идэвхгүй	
		Идэвхтэй	
		Татан буугдсан	
		Түр зогсоосон	
		Шинээр байгуулагдсан	
4.	Байгууллагын үйлдлийн төрөл	шинээр бүртгэх	
		түр зогсоох	
		татан буугдах	
		ангилал өөрчлөх	
5.	Байгууллагын хэв шинж	Дээд боловсрол	Консерватор
			Эрдэм шинжилгээ
			Үйлдвэрлэл
			Сургалт
		Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол	Ердийн
			Тусгай
			Сувиллын
			Асрамжийн
			Халамжийн
			төрөлжсөн
			Гүнзгийрүүлсэн /Биеийн тамирын/
			Гүнзгийрүүлсэн /Бусад/
			Гүнзгийрүүлсэн /Хөгжим, урлагийн/
			Гүнзгийрүүлсэн /Цэргийн /
			Олон улсын хөтөлбөртэй / КЕМБРИЖ/
			Олон улсын хөтөлбөртэй /АЙ БИ/
			Олон улсын хөтөлбөртэй /ОКСФОРД/
			Олон улсын хөтөлбөртэй /ЮК/
			Олон улсын хөтөлбөртэй /ЖИ СИ ЭС И/
			Олон улсын хөтөлбөртэй /Бусад/

		Техникийн болон мэргэжлийн боловсрол	Политехник коллеж Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв Мэргэжлийн сургалтын байгууллага
6.	Зөвшөөрлийн дүгнэлт	Шалгуур хангаагүй Шалгуурыг бүрэн хангасан Шалгуурыг хэсэгчлэн хангасан	
7.	Зөвшөөрлийн хугацаа	Мэргэжлийн боловсрол Техникийн боловсрол	1 жил 2.5 жил 1.5 жил 3 жил
8.	Магадлан итгэмжлэлийн төрөл	Дотоодын Олон улсын	
9.	Магадлан итгэмжлэлийн хөтөлбөр	Дотоодын хөтөлбөрийн тоо Олон улсын хөтөлбөрийн тоо	
10.	Салбар, бүрэлдэхүүн сургуулийн төлөв	Идэвхтэй Идэвхгүй	
11.	Салбар, бүрэлдэхүүн сургуулийн төрөл	Салбар сургууль Бүрэлдэхүүн сургууль	
12.	Хуулийн этгээдийн төрөл	Салбар, бүрэлдэхүүн сургуулиас шилжиж ирсэн Хөтөлбөрөөс шилжүүлсэн	
13.	Хэрэгжүүлдэг боловсролын түвшин	Бакалаврын боловсрол Дипломын боловсрол Докторын боловсрол Магистрын боловсрол	
14.	Магадлан-Явц	Хүсэлт гаргасан Гэрээ байгуулсан Өөрийн үнэлгээний үе Хөндлөнгийн үнэлгээний үе Шийдвэр гаргах үе Шийдвэр гарсны дараах үе	
15.	Магадлан-Тушаал шийдвэр	5 жил магадлан итгэмжлэх 1-2 жил магадлан итгэмжлэх Хугацаанд өөрчлөлт оруулах Цуцлах Хөндлөнгийн үнэлгээ хийсэн мэдэгдэл Урьдчилан магадлан итгэмжлэх Удирдах зөвлөл	
16.	Магадлан-Тушаал, шийдвэр гаргагч	Дээд боловсролын комисс	

2. Иргэний бүртгэл мэдээлэлд чиглэсэн

- | | |
|------------------------------|---------------------------------|
| 1. Боловсролын зэрэг | 14. Хаяг: Аймаг/нийслэл |
| 2. Боловсролын түвшин | 15. Хаяг: Баг/хороо |
| 3. Гадаадын харьяат эсэх | 16. Хаяг: Байшин/байр |
| 4. Гар утас | 17. Хаяг: Гудамж/хороолол |
| 5. Иргэншил | 18. Хаяг: Сум/дүүрэг |
| 6. Мэргэжил | 19. Хаяг: Үндсэн захиргаа |
| 7. Мэргэжлийн ерөнхий чиглэл | 20. Хөгжлийн бэрхшээлийн төрөл |
| 8. Нас | 21. Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр |
| 9. Нэр | 22. Хөгжлийн бэрхшээлтэй эсэх |
| 10. Овог | 23. Хүйс |
| 11. Өрхийн мэдээлэл | 24. Бүртгэлийн төрөл |
| 12. Регистрийн дугаар | 25. Цахим шуудангийн хаяг |
| 13. Хагас/бүтэн өнчин эсэх | 26. Чадвар алдалтын хувь |

3. Ажилтны бүртгэл мэдээлэлд чиглэсэн

- | | | | |
|-----|---|-----|---|
| 27. | Ажилтны түвшин | 59. | Цол, шагнал олгосон байгууллага |
| 28. | Ажилтны шилжилт хөдөлгөөн /нэмэгдсэн/ | 60. | Цол, шагнал олгосон огноо |
| 29. | Ажилтны шилжилт хөдөлгөөн /хасагдсан/ | 61. | Цол, шагналын дугаар |
| 30. | Албан тушаалын зэрэг | 62. | Ажлаас гарсан огноо |
| 31. | Албан тушаалын код | 63. | Ажил - байнгын/Түр |
| 32. | Багшийн ур чадварын түвшин | 64. | Ажил - Бүтэн цагийн/Цагийн |
| 33. | Багшлах эрхтэй багш эсэх | 65. | Удирдах ажилтан эсэх |
| 34. | Байгууллагын үйл ажиллагааны орлогоос цалинждаг эсэх | 66. | Үйлдвэрчний эвлэлийн гишүүн эсэх |
| 35. | Боловсролын салбарт ажилласан жил | 67. | Ажилтны төлөв |
| 36. | Гэрээгээр ажиллаж байгаа эсэх | 68. | Харьяалах нэгж |
| 37. | Давхар хөдөлмөр эрхэлдэг эсэх | 69. | Харьяалах нэгжийн код |
| 38. | Зайнаас ажилладаг эсэх | 70. | Харьяалах нэгжийн төрөл |
| 39. | Мэргэжил дээшлүүлсэн байдал | 71. | Харьяалах нэгжийн дээд нэгж |
| 40. | Мэргэжил дээшлүүлсэн хугацаа | 72. | Заадаг хичээлийн нэр |
| 41. | Мэргэжил дээшлүүлсэн хугацаа /дууссан/ | 73. | Заадаг хичээлийн индекс |
| 42. | Мэргэжил дээшлүүлсэн сургалт дууссан эсэх | 74. | Багшаар бүртгэх эсэх |
| 43. | Мэргэжлийн бус багш эсэх | 75. | Багшийн код |
| 44. | Мэргэжлийн зэрэг | 76. | Багшийн ачаалал /Сургалтын ачаалал/ |
| 45. | Сайн дурын ажилтан эсэх | 77. | Багшийн ачаалал /Эрдэм шинжилгээ, судалгааны ачаалал/ |
| 46. | Сайн дурын ажилтан эсэх /гадаад/ | 78. | Багшийн ачаалал /Бусад ачаалал/ |
| 47. | Төсвөөс цалинждаг эсэх | 79. | Үндсэн цалинтай эсэх |
| 48. | Тухайн албан тушаалд ажилласан жил /томилогдсон огноогоор бодох/ | 80. | Үндсэн цалин |
| 49. | Тухайн байгууллагад ажилласан жил /анх томилогдсон огноогоор бодох/ | 81. | Цалинжих хэлбэр |
| 50. | Тухайн салбарт ажилласан жил | 82. | Цалингийн суурь |
| 51. | Тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа эсэх /тэтгэвэрт гарсан огноогоор бодох/ | 83. | Тогтмол цалин |
| 52. | Улсад ажилласан жил | 84. | Нэмэгдэл хөлс |
| 53. | Үндсэн ажилтан эсэх | 85. | Нэмэгдэл цалин хөлс |
| 54. | Үндсэн багш эсэх | 86. | Цалин тооцох суурь |
| 55. | Үндсэн багшаар багшилсан хугацаа | 87. | Үндсэн цалингийн хуваарь тогтмол эсэх |
| 56. | Хавсран ажиллаж буй багш эсэх | 88. | Үндсэн цалингийн хуваарь давтамжаар |
| 57. | Цагийн багш эсэх | 89. | Зөвлөлийн нэр |
| 58. | Цол, шагнал | 90. | Зөвлөлийн код |
| | | 91. | Зөвлөлийн төрөл |
| | | 92. | Зөвлөл-Төлөв |
| | | 93. | Зөвлөл-Харьяалах комисс хороо |
| | | 94. | Зөвлөл-Тушаал шийдвэрийн огноо |
| | | 95. | Зөвлөл-Үүрэг, роль |
| | | 96. | Ажлын газар /рд/ |
| | | 97. | Ажлын утас |
| | | 98. | Албан тушаал |

4. Суралцагч, төгсөгчийн бүртгэл мэдээлэлд чиглэсэн

- | | | | |
|------|---|------|---|
| 99. | Амьдарч буй сууц | 104. | насан туршийн боловсролын төвөөс ЕБС-д шилжсэн эсэх |
| 100. | Асран хамгаалагч төрөл | 105. | Нөхөн сэргээх үйлчилгээний төрөл |
| 101. | Дотуур байранд орох хүсэлт гаргасан эсэх | 106. | Сургуулиас гарсан огноо |
| 102. | Дүрэмт хувцас | 107. | Сургуулиас гарсан шалтгаан |
| 103. | Дүрэмт хувцас авах боломжгүй өрхийн суралцагч | 108. | Сургуульд огт ороогүй эсэх |
| | | 109. | Сургуульд ороод завсардсан эсэх |

- | | |
|---|---|
| <p>110. Сургуульд ороод завсардсан эсэх /анги/
 111. Түр ажил эрхэлдэг эсэх
 112. Үе тэнгийн дээрэлхэлтийн тохиолдлын төрөл
 113. Халамж эдэлдэг эсэх
 114. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр бүртгэгдсэн тохиолдлын төрөл
 115. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр тус бүрээр бүртгэгдсэн тохиолдол
 116. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж тогтоогдоогүй дуудлага, мэдээллийн тоо
 117. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэж тогтоогдсон дуудлага мэдээллийн тоо
 118. Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн кейс
 119. Хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, нөлөөллийн ажил
 120. Шилжилт хөдөлгөөн - нэмэгдсэн шалтгаан /суралцагч/
 121. Шилжилт хөдөлгөөн - хасагдсан шалтгаан /суралцагч/
 122. Шилжилт хөдөлгөөн хийгдсэн огноо
 123. Шуурхай тусламж - Эрсдэлийн болон аюулгүй байдлын үнэлгээнд хамрагдсан байдал
 124. Шуурхай тусламж- Нөхцөл байдлын үнэлгээнд хамрагдсан байдал
 125. Шуурхай тусламж-Аюулгүй төлөвлөгөө хийж, хамгаалагдсан байдал
 126. Шуурхай тусламжийн үйлчилгээ авсан эсэх
 127. Шуурхай тусламжийн үйлчилгээний төрөл
 128. Элссэн огноо
 129. Элссэн тушаал, шийдвэрийн дугаар
 130. Элссэн хичээлийн жил
 131. Элссэн хичээлийн улирал
 132. Ажилд орсон огноо
 133. Ажил олгогч
 134. Ажил мэргэжлийн ангилал
 135. Одоо ажиллаж байгаа эсэх
 136. ЭЕШ өгсөн эсэх
 137. ЭЕШ өгөхөөр бүртгүүлсэн эсэх</p> | <p>138. Диплом, үнэмлэх,гэрчилгээний бүртгэлийн дугаар
 139. Диплом, үнэмлэх,гэрчилгээний дугаар
 140. Мэргэжлийн диплом, үнэмлэх олгосон тушаал, шийдвэрийн гаргасан байгууллага
 141. Мэргэжлийн диплом, үнэмлэх олгосон тушаал, шийдвэрийн дугаар
 142. Мэргэжлийн диплом, үнэмлэх олгосон тушаал, шийдвэрийн огноо, дугаар
 143. Суралцсан хугацаа /элсэлт болон төгсөлт хийсэн огноогоор тооцоолох /
 144. Төгсөөд ажилд орсон байгууллага
 145. Төгсөөд дараагийн боловсролын түвшинд элссэн эсэх</p> |
|---|---|

Иргэний, ажилтны, суралцагчийн болон төгсөгчийн бүртгэл мэдээллийн дэлгэрэнгүй үзүүлэлт:

№	Төрөл	Үзүүлэлт
1	Ажилтны төлөв	Ажиллаж байгаа
		Түр зогсоосон
		Чөлөө авсан
		Туршилтын хугацаа
		Идэвхгүй
2	Ажилтны түвшин	Гүйцэтгэх ажилтан
		Туслах ажилтан
		Удирдах ажилтан
3	Ажилтны шилжилт хөдөлгөөн /нэмэгдсэн/	Бусад
		Гадаадын сургуулиас ирсэн
		Дотоодын сургуулиас ирсэн
		Өөр мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаас ирсэн
		Сургуулиа төгсөж ирсэн
		Сургууль дотроо ажлаа өөрчилсөн
		Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн
4	Ажилтны шилжилт хөдөлгөөн /хасагдсан/	Байгууллага дотроо албан тушаалаа өөрчилсөн
		Боловсролын бус байгууллагад шилжсэн
		Бусад
		Гадаад явсан
		Гадаадад сургуульд суралцахаар шилжсэн
		Гэмт хэрэгт татагдсан
		Дотоодод сургуульд суралцахаар шилжсэн
		Ерөнхий боловсролын сургуульд ажиллахаар шилжсэн
		Их, дээд сургуульд ажиллахаар шилжсэн
		Нас барсан
		Орон тооны цомхотголд орсон
		Өөр аймаг, хотын сургалтын байгууллагад шилжсэн
		Өөр мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад ажиллахаар шилжсэн
		Тухайн аймаг, хотынхоо цэцэрлэгт шилжсэн
		Тэтгэвэрт гарсан
		Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад ажиллахаар шилжсэн
		Хувиараа ажил эрхлэх
		Хувийн хэвшлийн ЕБС-д шилжсэн
		Төрийн өмчийн ЕБС-д шилжсэн
Орон нутгийн ЕБС-д шилжсэн /аймгийн төв, суманд/		
Нийслэл ЕБС-д шилжсэн		
5	Албан тушаалын зэрэг	гутгаар
		дөтгөөр
		дэд
		тэргүүн
6	Албан тушаалын төрөл	Дотоод хяналтын ажилтан
		Тусгай сургуулийн хөдөлгөөн засалч багшийн тоо
		Асрагч багш
		Ажил мэргэжлийн чиг баримжааны ажилтан
		Арга зүйч-багш
		Архив бичиг хэргийн ажилтан
		Ахлах мэргэжилтэн
		Бичиг хэрэг, архивын ажилтан
		Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн
		Бусад
		Гадаадын мэргэжилтэн
		Галч
		Дарга
Дотоод чанарын баталгаажилт, статистик хариуцсан ажилтан		

	Дотуур байрын бусад ажилтан
	Дотуур байрын жижүүр
	Дотуур байрын тогооч
	Дотуур байрын туслах тогооч
	Дотуур байрын үйлчлэгч
	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын тогооч
	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын туслах тогооч
	Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, хоолны тогооч
	Ерөнхий нягтлан бодогч
	Жижүүр, манаач, сахиул
	Жолооч
	Захирал
	Захиргаа аж ахуйн менежер
	Манаач, жижүүр
	Мужаан
	Нийгмийн ажилтан
	Нийгмийн ажилтан /дотуур байр/
	Нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн сургалт хариуцсан арга зүйч
	Номын сангийн ажилтан
	Нягтлан бодогч
	Нярав
	Сантехникч
	Сайн дурын ажилтан
	Статистик мэдээлэл, цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтэн
	Статистик, мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
	Сургалтын арга зүй, багшийн мэргэжлийн хөгжил, гүйцэтгэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
	Сургалтын менежер
	Сэтгэл зүйч
	Сэргээн засалч
	Тогооч
	Тогооч /туслах/
	Тоног төхөөрөмж, цахим сүлжээ, мэдээллийн сан хариуцсан ажилтан
	Төрийн захиргааны мэргэжилтэн
	Уурын зуухны галч
	Үйлчлэгч
	Насан туршийн боловсролын багш
	Үндсэн багш / Бүлгийн/
	Үндсэн багш / Дуу хөгжмийн/
	Үндсэн багш / Биеийн тамирын/
	Үндсэн багш / Тусгай мэргэжлийн багш/
	Үндсэн багш / Ээлжийн бүлгийн/
	Үндсэн багш / Нүүдлийн бүлгийн/
	Үндсэн багш /Явуулын багш/
	Үндсэн багш / Бага ангийн/
	Үндсэн багш /Дунд ангийн/
	Үндсэн багш /Ахлах ангийн/
	Үндсэн багш / Дунд болон ахлах ангийн/
	Үндсэн багш / Мэргэжлийн бус/ы
	Хоол зүйч
	Цагийн багш
	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажилтан
	Хөрөнгө оруулалт төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн

		Хүний нөөц, гадаад харилцаа хариуцсан ажилтан
		Хүүхдийн хөгжил хамгаалал, тэгш хамран сургалт, сурах бичиг, сургалтын орчин, Хоол үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн
		Хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
		Цахилгаанчин
		Цахим сургалтын агуулга, хөгжүүлэлт, сургалтын нөөц хариуцсан ажилтан
		Цахим технологи, мэдээллийн сүлжээ хариуцсан мэргэжилтэн
		Эмч
		Эмч /дотуур байр/
		Эрхлэгч
7	Амьдарч буй сууц	Өөрийн гэрт
		Айлд /Төрөл садансгийндаа/
		Дотуур байр /сургуулийнхаа/
		Асрамжийн газарт
		Бусад газарт
		Дотуур байр /бусад сургуулийн/
		Түрээсийн байр
		Дотуур байр /нэгдсэн/
		Дотуур байр /бусад төрлийн/
8	Асран хамгаалагч төрөл	Эцэг эх
		Эмээ өвөө
		Төрөл садан
		Дотуур байрны багш
		Асрамжийн газрын хүмүүжүүлэгч
		Бусад хүний
		Асрамжлах хүнгүй
9	Багшийн ур чадварын түвшин	Ахлах багш
		Багш
		Дадлагажигч багш
		Мастер багш
		Дэд профессор багш
		Профессор багш
10	Боловсролын зэрэг	Бакалавр
		Бусад /үйлдвэрлэлийн зохих дадлага, туршлагатай эсхүл мэргэжлийн өндөр зэрэгтэй/
		Бүрэн дунд
		Диплом
		Доктор
		Магистр
		Суурь
11	Боловсролын түвшин	Бага
		Боловсролгүй
		Бүрэн дунд
		дээд
		мэргэжлийн
		Суурь
		техникийн
		Диплом
		Доктор
		Магистр
		Бакалавр
12	Дүрэмт хувцас	Жилет
		Ноосон цамц
		Өмд
		Пиджак
		Сарафан
		Цэнхэр цамц

		Юбка
13	Мэргэжил дээшлүүлсэн байдал	Их, дээд сургуулийн багш, судлаачтай хамтран инновацын төсөл, судалгаанд ажиллаж мэргэжил дээшлүүлсэн Үйлдвэрлэлийн орчинд мэргэжил дээшлүүлсэн Цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан
14	Мэргэжил дээшлүүлсэн байдал /сургалт/	Ажлын байран дахь сургалт Зорилтот сургалт Сонголтот сургалт Үндсэн сургалт
15	Мэргэжил дээшлүүлсэн байдал /хаана/	Бүсийн хэмжээнд Гадаадад Орон нутгийн хэмжээнд Улсын хэмжээнд
16	Мэргэжил дээшлүүлсэн хугацаа	1, түүнээс дээш сар 11-29 хоног 1-3 хоног 4-10 хоног
17	Мэргэжлийн ерөнхий чиглэл	Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик Бизнес, удирдлага, эрх зүй Боловсрол Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж Мэдээлэл харилцаа холбооны технологи Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй Урлаг, хүмүүнлэг Үйлчилгээ Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэлзүй Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал
18	Мэргэжлийн зэрэг	Ахлах Заах аргач Зөвлөх Тэргүүлэх
19	Нөхөн сэргээх үйлчилгээний төрөл	Кейс менежментийн төлөвлөгөө гаргаж, ажилласан суралцагчийн Нийгмийн ажлын үйлчилгээнд хамрагдсан суралцагчийн Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан суралцагчийн Боловсролын үйлчилгээнд хамрагдсан хүчирхийлэлд өртсөн суралцагчийн /"Боловсролын байгууллагын сургалтын орчин ба дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам"-ын 3.2-р заалт/ Гэр бүлээс нь тусгаарлаж хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулсан суралцагчийн /ТХБ/НЦҮТ/Дотуур байр/
20	Өрхийн мэдээлэл	Нэн ядуу өрх эсэх АБТ-ээс доогуур орлоготой өрх эсэх Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх эсэх Эцэг, эхийн аль нэг нь малчин өрх эсэх Эцэг, эх нь хоёулаа ажилгүй өрх эсэх Эцэг, эх нь хоёулаа тэтгэвэр тогтоолгосон өрх эсэх Цаатан өрхийн суралцагч эсэх 2 ба түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургуульд сурдаг өрх эсэх
21	Үе тэнгийн дээрэлхэлтийн тохиолдлын төрөл	Бие махбодын Сэтгэл санааны Харилцааны Цахим Бусад
22	Үндсэн багш	Ерөнхий эрдмийн Мэргэжлийн
23	Үндсэн багш эсэх	Үндсэн багш Хавсарсан багш
24	Үндсэн захиргаа	Багануур

		Багахангай
		Баянгол
		Баянзүрх
		Налайх
		Сонгинохайрхан
		Сүхбаатар
		Хан-Уул
		Чингэлтэй
		Архангай
		Баян-Өлгий
		Баянхонгор
		Булган
		Говь-Алтай
		Говьсүмбэр
		Дархан-Уул
		Дорноговь
		Дорнод
		Дундговь
		Завхан
		Орхон
		Өвөрхангай
		Өмнөговь
		Сэлэнгэ
		Төв
		Увс
		Ховд
		Хөвсгөл
		Хэнтий
25	Үндсэн захиргаа /бүс/	Баруун бүс
		Зүүн бүс
		Төвийн бүс
		Улаанбаатар
		Хангайн бүс
26	Харьяалах нэгжийн төрөл	Алба
		Баг
		Газар
		Хэлтэс
		Тасаг
		Зөвлөл
		Нэгж
		Лаборатори
		Хороо
		Хүрээлэн
27	Хөгжлийн бэрхшээл хэлбэр	Бусад
		Дауны хам шинж
		Сонсголын
		Сэтгэц / Аутизмын/
		Сэтгэц / Оюуны хөгжлийн/
		Хавсарсан
		Харааны
		Хөдөлгөөний
		Ярианы
28	Хөгжлийн бэрхшээлийн төрөл	Олдмол
		Төрөлхийн
		өвчний
29	Хүйс	Эмэгтэй
		эрэгтэй
30	Хүний бүртгэлийн төрөл	Ажилтан
		Суралцагч

		Төгсөгч
		Элсэгч
